



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.07.20, БААСАН ~ №141 (940)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Шинэ ургац гарч эхэлсэн ч ногооны үнэ өндөр хэвээр байна

Ирэх сард хүнсний ногооны үнэ хямдарна гэсэн хүлээлт үүсчээ. > 4



FINANCIAL TIMES-ИЙН
ШИЛДЭГ НИЙТЛЭЛҮҮД
ТАНД ХҮРЧ БАЙНА > 7

Lotte Mart ирэх жил Монголд салбараа нээнэ

Хилийн чанадад Монгол, Вьетнамын зах зээлийг онилж эхэлжээ. > 5

ZGM DAILY

FULL
ENGLISH PAGE
INSIDE

> 6

ОНЦЛОХ


УЛС ТӨР

Төрийн байгууллагын бүх дарга нар ирэх сарын 1-н гэхэд ажилдаа орохыг ЕС даалгав. **Ээлжит бус чуулган зарлавал** ирцийн асуудал л амаргүй гэж УИХ-ын ТГ-ын дарга хэллээ. **Цэцэрлэгт хүрээлэнгийн үйл** ажиллагаа хяналтаас гарсныг НИТХ-ын дарга онцлов. **Д.Тэрбишдагва: Оюутолгойн** шалгалтын дүгнэлтийг танилцуулахад бэлэн.

ЭДИЙН ЗАСАГ

Монголын хөрөнгийн биржийн гишүүнчлэлийн журам шинэчлэгдэн батлагдлаа. **Гадаад иргэдийн 27 хувь нь** уул уурхайн салбарт ажиллаж байна. **Авто тээврийн салбарын** орлого 298.3 тэрбум төгрөгт хүрэв. **Бүртгэлтэй ажилгүй иргэдийн** 47.6 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байна. **ТОП 20 индекс 0.32 хувиар** өсч, 19701.25 нэгж болов.

ТОП-20 индекс



НИЙГЭМ

ЖАЙКА-гийн тусламжаар автобусаас ялгарах хорт торгтийн хэмжээг бууруулна. **ХСҮТ-ийн зоорийн давхар** усанд автсанаас болж шинээр авсан туяаны аппарат эвдэрчээ. **Төрийн өмчийн үл хөдлөх** хөрөнгө, газрыг дахин үнэлж эхэллээ. **Нийслэлийн Даншиг наадам** ирэх сарын 4, 5-нд "Хүй долоон худал"-т болно.

ДЭЛХИЙ

Сөүлийн шүүх 2014 оны Се-волийн ослын хохирогсдод 200 сая won олгохоор шийдвэрлэв. **Туркт хоёр жил үргэлжилсэн** онц байдлын хугацаа пүрэв гарагт дуусгавар боллоо. **Трампын захиргаа уранд** импортын татвар ногдуулах асуудлыг судална. **Унгарт батлагдсан Соросын** эсрэг хуулийг Брюссель хатуу шүүмжилсэн байна. **Европын Холбоо Хятадын** цахилгаан дугуйнд тариф ногдуулахаа зарлалаа.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2018.07.20



МОНГОЛД ТАРИАЛАНЧ, МАЛЧИД Л УСЫГ ҮНЭГҮЙ АШИГЛАЖ БАЙНА



Усны 50 гаруй хувийг хэрэглэдэг хөдөө аж ахуйн салбар цэнхэр "алт"-ыг ашигласныхаа хариуд ширхэг зоос ч төлдөггүй. Харин малчид болон тариаланчдад ус ашигласны төлбөр ногдуулахаар салбарынхан хуулийн төсөлд өөрчлөлт оруулахаар өргөн барьсан ч УИХ буцаажээ. ▶ 3

УЛСТӨР

Д.Тогтохсүрэн: Тавантолгойг хөдөлгөсөн нь чуулганы гол амжилт

Б.Энхжаргал
@enkhjrglZGM

УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэнтэй ярилцлаа.

-Хаврын чуулган завсарлаад удаагүй байна. Өнгөрсөн чуулганы үр дүнг та хэрхэн дүгнэж байгаа вэ?

-Гурван сарын хугацаанд хуралдсан хаврын чуулганы үр дүнг би сайнаар үнэлнэ. Энэ тухайд би гуравхан зүйл хэлье. Нэгдүгээрт, Тавантолгойг хөдөлгөхөөр болсныг юуны түрүүнд дурдах нь зүйтэй. Олон жил

талцаж маргасан асуудлыг нэг тийш болгож, олон түмний хяналт дор, нээлттэй, ил тод байдлаар төдийгүй олон улсад мөрддөг дүрэм журмынх нь дагуу хөрөнгийн биржид хувьцаа гарган, 30 хувийг нь худалдах шийдвэр гаргалаа.

Дэлхийн зах зээлд нүүрсний үнэ харьцангуй өндөр байгаа үед хөрөнгийн зах зээлд гаргах нь цаг үеэ олсон чухал шийдвэр болсон. Одоо гагцхүү хэрэгжилт нь хэр үр дүнтэй байх, цаашлаад үр өгөөжийг нь ард түмэнд хэрхэн хүртээх вэ гэдэг л чухал.

▶ 2



Google Европын холбоог шүүхэд өгнө гэв

Алекс Баркер

Европын холбоо Андройд системийг монополийн эсрэг хуулийн дагуу дээд хэмжээ буюу 4.3 тэрбум еврогоор торгосныг Google яаралтай шүүхэд өгөхөө мэдэгдэв. Тус компани ухаалаг утас болон бусад мобайл хэрэгслийн ашигтай бизнес загварыг нь нураахыг оролдож байна гэж Брюсселийг буруутгажээ. Европын комисс Андройд үйлдлийн системээ шинэчлэхэд 90 хоногийн хугацаа өгсөн. Энэ хугацаанд, өрсөлдөөнийг хаах хууль бус хязгаарлалтаа зогсоох

ба Google-ийн хайлтын системд нэмэлт замууд оруулахыг шаардсан байна. Европын комисс Америкийн технологийн групптэй найман жил монополийн эсрэг асуудлаар тэмцэлдсэний эцэст хамгийн чухал гэгдэх энэхүү шийдвэрийг гаргажээ. Компанийн ерөнхий захирал Сундар Пичай Financial Times-т ярихдаа "Андройдыг дэмждэг бизнес загварыг эсэргүүцэж, хүмүүс утсаа хэрхэн ашиглаж буйг үл харгалзсан шийдвэрийн эсрэг зарга үүсгэнэ" хэмээв.

▶ 7

ЗГМ: ИНФОГРАФИК

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, БИЕЙН ТАМИР, СПОРТ

Соёл урлагийн байгууллагын ажилчид

2563
Театр, чуулга, цирк

724
Музей

808
Номын сан

2339
Соёлын төв (ордон)

571
Киноны байгууллага

Улсын хилээр орсон жуулчид (улсаар)

469,309
Бүгд

142,481
БНХАУ

106,885
ОХУ

74,921
БНСУ

22,519
Япон

16,667
АНУ

Сүм, хийд (шашны төрлөөр)

344
Сүм, хийд

136
Будда

344
Христ

344
Ислам

344
Бусад

Биеийн тамир, спортын байгууллага

31
Байгууллага

1,118,400
Хичээллэгчид

Үндэсний статистикийн хороо

ЭДИЙН ЗАСАГ

Орлого нэмэгдэхээр зарлагаа дагаж өсгөдгөө хэзээ болих вэ

З.Цэлмэг
@tselmegZGM

Иргэд, аж ахуйн нэгжүүд татварын орлогоороо энэ оны эхний хагас жилийн төсвийн 80.4 хувь буюу 3.7 их наяд төгрөгийг бүрдүүлсэн байна. Харин төсвийн ерөнхийлөн захирагч энэ мөнгөний 95.9 тэрбумыг зээлэнд төлсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 2.1 хувь өссөн дүн юм. Өөрөөр хэлбэл, нийгмийн даатгалын орлогын эхний хагас жилийн өсөлт болох 92.7 тэрбумыг дахиад 3.2 тэрбум төгрөгтэй тэр чигт нь өрөнд тавиад туучихлаа гэсэн үг. Ингэснээр 2018 оны нэгдүгээр хагас жилийн төсвийн зарлагын 4.4 хувийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл эзэлж буйг лхагва гарагт Үндэсний статистикийн хорооноос танилцуулсан нийгэм, эдийн засгийн ээлжит тайланд дурдсан байна. Төсөвт төлөвлөснөөр энэ онд эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд 286.1 тэрбум төгрөг төлөх бөгөөд одоогоор энэ дүнгийн гуравны нэгийг л Засгийн газар барагдуулаад байгаа гэсэн үг юм. Төсвийн зардлын 86 хувийг урсгал зардал эзэлж байна. Урсгал шилжүүлэг өнгөрсөн оны мөн үеэс 10.9 хувиар өссөн байна.

▶ 5

АЛТ

1217.30
0.86%

ЗЭС

6150
0.03%

10-ЧИНГИС БОНД

94.47
0.05%

ХУРАЛДАЙ БОНД

108.16
0.06%

ГЭРЭГЭ БОНД

95.49
0.02%

АМ.ДОЛЛАР

2461.28

ЮАНЬ

364.21

РУБЛЬ

38.91

Улс төр

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

Д.Тогтохсүрэн: Тавантолгойг хөдөлгөсөн нь чуулганы гол амжилт

Нүүрсний үнэ өндөр байгаа үед “Тавантолгой” IPO хийх нь зөв

◀1

Хоёрдугаарт, Улсын бүртгэлийн багц хуулийг баталсан. Энэ бол бүртгэлийн системд хийж буй эрх зүйн томоохон шинэчлэл. Бүртгэлийг хүнд сурталгүй, шуурхай болгоход нэлээд ахиц дэвшил гаргасан хууль болсон. Эцрст нь, УИХ ард иргэдийн амьжиргааг сайжруулах чиглэлд нэлээд үр дүн гаргасан гэж хэлнэ. 2019 оны төсвийн хүрээний мэдэгдлийг баталсан. Үүгээр бид цалин, хөлс, тэтгэврийг тодорхой хэмжээнд нэмэх нь зүйтэй гэх шийдэлд хүрсэн. Цаашлаад банкны зээлийн хүүг бууруулах чиглэлд анхаарах зайлшгүй шаардлага байна гэж үзсэн. Мөн эдийн засгийн өсөлтийг ард түмэнд хүртээх шаардлагатай гэж үзээд шийдвэр гаргасан. Энэ агуулгаараа хаврын чуулган үүргээ гүйцэтгэсэн.

-Хаврын чуулганы хугацаанд хэд хэдэн томоохон ажлын хэсгийн дүгнэлтийг сонсох байсан ч амжсангүй. Тухайлбал, “Оюутолгой”-н ажлын хэсгийнхэн шалгалтаа дууссан ч Засгийн газраас бичиг хүлээж байна гэх шалтгаанаар чуулганыг өндөрлүүлсэн. Өнөөдрийн байдлаар хөөр тал ойлголцолд хүрээгүй...

-Хаврын чуулган эхлэхээс өмнө “Оюутолгой”-той холбоотойгоор ард иргэдийн зүгээс нэлээд шүүмжлэл гарсан. Тиймээс УИХ-аас 2009, 2015 онд “Оюутолгой”-той байгуулсан гэрээнд үнэлэлт дүгнэлт өгөх Ажлын хэсгийг байгуулсан. Сүүлд өргөжүүлээд явсан, хажуугаар нь дэд ажлын



хэсгүүдийг ч ажиллуулсан. Ажлын хэсгийнхэн дүгнэлтээ УИХ-д албан ёсоор өргөн бариагүй. Явцын талаар мэдээлж байгаагаас харахад “Оюутолгой”-той холбоотой тодорхой зөрчил цөөнгүй юм билээ. “Оюутолгой”-н хувьд миний байр суурь тун тодорхой. Тухайлбал, 2015 онд байгуулсан Дубайн гэрээг хүчингүй болгох ёстой. Энэ гэрээний хүрээнд Монгол Улсын эрх зэргийг олон зүйл бий. Ээлжит бус юм уу намрын чуулганаар энэ асуудлыг нэлээд нухацтай ярих байх гэж бодож байна.

-УИХ-ын гишүүдийн сахилга, хариуцлага, ёс зүйтэй холбоотой асуудал энэ хуга-

цаанд нэлээн хөндөгдсөн. Яг ийм асуудлаас болж парламентын нэг гишүүн бүрэн эрхээсээ буугаад байна. Тиймдээ ч УИХ-ын Дэгийн тухай хуулийг өөрчилсөн байх. Гэвч чуулганы гуравны нэгт нь УИХ, байнгын хорооны хуралдаанд суугаагүй бол эгүүлэн татах заалтыг гишүүд дэмжсэнгүй. Тус хуулийн төслийн Ажлын хэсэгт орж ажилласны хувьд энэ заалтыг унасан талаар ямар тайлбар өгөх вэ?

-Бид энэ хуулийн өөрчлөлтийн хүрээнд гурван зүйлийг тодорхойлохоор шийдсэн юм. Нэгдүгээрт, УИХ-ыг, гишүүдийг хариуцлагажуулъя. УИХ-аас гаргаж буй хуулийг чанаржуулахаар зорьсон. Энэ агуулгаар гишүүд хурлаа таслаад байвал эгүүлэн татдаг болох, байнгын хорооны хуралд гурав ба түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр

суухгүй бол хасъя гэх мэтээр хариуцлагын заалтыг оруулсан л даа. Хамгийн гол нь хүний өмнөөс кноп дардгийг болиулаад хурууны хээгээ уншуудаг болох заалт багтаасан.

Үндсэн хуулиар хотын статусыг бий болгож байна

Гэвч хэлэлцүүлгийн явцад эгүүлэн татах, байнгын хорооны гишүүнээс хасах заалт нь Үндсэн хууль зөрчиж байна гэж үзээд болиулчихсан. УИХ-ын бүрэн эрхэд халдана гэж үзсэн хэрэг. Гэхдээ энэ заалтыг Үндсэн хуулийн өөрчлөлтөд багтааж өгсөн. Энэ хуулийн төслийг УИХ-д өргөн барихад бэлэн

ЗГМ:ТОДРУУЛГА
Ц.Цолмон: ХЗБХ ээлжит бус чуулганы товыг тогтооно

Б.Энх
ЗГМ



Ээлжит бус чуулган хуралдуулах албан бичгийг Ерөнхийлөгч Х.Баттулгаас ирүүлсэнтэй холбогдуулан УИХ-ын Тамгын газрын дарга Ц.Цолмонгоос зарим зүйлийг тодрууллаа.

-Ерөнхийлөгч Х.Баттулга болон Л.Оюун-Эрдэнэ нарын УИХ-ын гишүүдээс ээлжит бус чуулган хуралдуулах саналаа УИХ-ын даргад хандан гаргасан гэсэн. Албан бичиг нь Тамгын газарт ирсэн үү? -Ирсэн.

-Ээлжит бус чуулган хуралдах уу? -Долдугаар сарын 18-нд УИХ-ын даргын дэргэдэх зөвлөл хуралдаж, ээлжит бус чуулган зарлах асуудлыг хэлэлцсэн. Хуралдаанаас уг асуудлыг холбогдох байнгын хороонд шилжүүлэхээр болсон. Хууль зүйн байнгын хорооны дарга хуралд оролцсон. Ойрын үед байнгын хороо хуралдах болов уу. Түүний дараа товыг зарлах байх.

-Байнгын хороо, ээлжит бус чуулган хуралдуулахад гишүүдийн ирц хүрэх болов уу? -Гишүүдийн дийлэнх нь тойрогтоо ажиллаж байна. Зарим гишүүн амарч байгаа. Ирц бүрдүүлэхэд амаргүй л байх болов уу.

-Ээлжит бус чуулган хуралдаа гэхэд Тамгын газар бэлэн үү? -Тамгын газар бэлэн байна. Техник хэрэгсэл, хүн хүч, гүйцэтгэх ажил үүргийн талаас ямар ч асуудал байхгүй. [ЗГМ]

[ЗГМ СОНИН]

"Засгийн газрын мэдээ" сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
"Блю Скай тауэр" 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР

zg.mn
ubinfo.mn
Дугаарын удирдагч
Б.Баяртогтох

8658000429112 00940

ЗАСГИЙН ГАЗАР
У.Хүрэлсүх: Төрийн байгууллагын бүх дарга нар ирэх сарын 1-н гэхэд ажилдаа ор



Б.Сэлэнгэ
ЗГМ

Төрийн бүх байгууллагын дарга нарыг ирэх сарын 1-н гэхэд ажилдаа орсон байхыг Ерөнхий сайд У.Хүрэлсүх даалгалаа. Ургац хураалт, хадлан тэжээл, өвс, тэжээлийн нөөцөө бүрдүүлэх, өвөлжилтийн бэлтгэлээ эртнээс хангахыг тэрбээр мөн анхааруулав.

Улсын онцгой комиссын хуралдааныг пүрэв гарагт Ерөнхий сайд хийлгэх үеэр дээрх үүргийг өгсөн юм. Энэ сарын 11-18-ны өдрүүдэд ихэнх нутгаар орсон аадар бороо, мөндрийн улмаас аймаг, нийслэлд үер бууж иргэд амь насаа алдан, автозам,

цахилгааны шугам сүлжээ, байгууллага, аж ахуйн нэгжид ихээхэн хохирол учирсан.

Мөн 13 аймгийн 116 км зам үерийн усанд автаж ноцтой эвдэрсэн тухай Зам, тээврийн хөгжлийн яам мэдээлэв. Үерийн улмаас автозамуудад 1.3 тэрбум гаруй төгрөгийн хохирол учирсан урьдчилсан тооцоо гаргажээ.

Нөхцөл байдлын талаар мэдээлэл сонссоны дараа Ерөнхий сайд У.Хүрэлсүх хэд хэдэн үүрэг, чиглэл өглөө. Гамшгийн өмнө бүгд бэлэн байж, хүний амь нас эрсдэх, эд материалын хохирол амсахаас урьдчилан сэргийлж ажиллахыг Онцгой комиссын гишүүд, удирдах албан тушаалтнуудад анхааруулав. [ЗГМ]

ЖИЖИГ ИННОВАЦИ. ТОМ АШИГ

САЯ \$-ЫН СУУТАН

ТУН УДАХГҮЙ

Bloomberg TV Mongolia

Нийтлэлчийн булан

Хөдөө аж ахуйн салбар усны төлбөрт ширхэг зоос ч төлдөггүй

Г.Байгал
@baigalZGM

Та ус ашигласныхаа төлөө төлбөр төлдөг үү. Орон сууцанд оршин суудаг нэг өрх сард дунджаар 30 мянган төгрөгийг усны төлбөрт өгдөг байна. Харин хот суурингийн жижиг үйлчилгээний газрууд энэ хэрэглээндээ 250-500 мянган төгрөг зарцуулдаг бол Монголын хамгийн том татвар төлөгч “Эрдэнэт үйлдвэр” ХХК Сэлэнгэ мөрний усыг ашигласныхаа хариуд 12 тэрбум орчим төгрөгийг төсөвт төвлөрүүлдэг аж. Хоногийн хоолоо арай ядан залгадаг хот, суурингийн айл өрхүүдээс эхлээд гудамж, тохой бүрийн өнцөгт байрладаг үсчин, зоогийн газар, том, жижиг



С.Батсайхан / ЗГМӨ

Монголд тариаланч, малчид л усыг үнэгүй ашиглаж байна

үйлдвэрүүд цөм цэнхэр “алт”-ыг ашигласныхаа төлбөрийг цаг алдахгүй төлөх гэж хичээцгээнэ. Гэтэл усны нийт хэрэглээний 50 гаруй хувийг бүрдүүлдэг хөдөө аж ахуйн салбар ханаж цадалгүй ус ашигласныхаа хариуд ширхэг зоос ч төлдөггүйг та мэдэх үү. Үнэ төлбөргүй тул хайрлах гамнах нь бүү хэл үнэгүй усаар тоглох нь холгүй ашиглах нь энүүхэнд. Мал маллаж, тариалан эрхэлдэг 190 мянга орчим өрх, аж ахуйн нэгж 60 сая давсан толгой мал, олон мянган га талбайгаа жилд 550 сая шоо метр усаар усалдаг гэж Байгаль орчин, аялал

“Эрдэнэт үйлдвэр” усны төлбөрт 12 тэрбум орчим төгрөг төлдөг

жуулчлалын яамнаас мэдээлж байна. Энэ бол бидний унд, ахуйн хэрэглээнээс бараг дөрөв дахин өндөр дүн. Тавантолгой тойрон талцан маргаж, Д.Мурат, Д.Гантулга нарыг төрийн түшээгийн суудлаас нь түдгэлзүүлэх асуудалд хаваржин анхаарсан УИХ ус хамгаалах ээлжит хуулийн төслийг “чимээгүй” хойшлуулчихав. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг энэ хаврын чуулганы сүүлчийн өдөр УИХ хэлэлцэж, уг төслийг батлахаар

санал хурааж байснаа больж, шуудхан чуулганы хаалтаа хийчихсэн юм. Усны “урт нэртэй” ээлжит хуулийн төсөлд эрхэм гишүүд ийн хайнга хандсан атлаа уг хуулийн төслийн нэг чухал өөрчлөлтийг унагаахаа мартсангүй. Уг “урт нэрт” хуулийн төслийг даган Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг өөрчлөхөөр өргөн барьсан ч орон нутгаас сонгогдсон гишүүд нүд үзүүлэж, “ад үзсээр” уг өөрчлөлтийг хууль санаачлагчид нь буцаачихав. Унагаж орхисон энэ өөрчлөлт нь ус үнэгүй хэрэглэдэг малчид, тариаланчдаас усны төлбөр авах тухай байв. Ингэхдээ 300 толгой хүртэлх малтай, нэг га хүртэлх талбайтай иргэдээс төлбөр авахаар тусгасан байв. Нэг хониноос багаар бодоход 19 төгрөг авснаар малчдаас 5.3 харин тариаланчдаас 2.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгасан аж. Гэвч эрхэм гишүүдийн олонх нь малчид, тариаланчид усаа үнэгүй хэрэглэсээр байх нь зүйтэй гэж үзжээ. Уг нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат энэ хуулийн төсөл нь эдийн засгийн хөшүүргээр дамжуулан, иргэдийг усны зохист хэрэглээнд чиглүүлж, нүүдлийн мал аж ахуйн аюулын харанга болсон бэлчээрийн доройтлыг сааруулах зорилготой хэмээн учирласан ч гишүүд тоосон ч үгүй. Усны бодлогыг ахиулна хэмээн албаныхны тайлбарласан энэ хуулийн төслийг эсэргүүцсэн



зарим гишүүний байр суурьт та анхаарлаа хандуулна уу. УИХ-ын гишүүн, Монголын тариаланчдын холбооны ерөнхийлөгч Ж.Энхбаяр “...Бид татвар нэмэхгүй гэж амлачихсан. Гэтэл татвар нэмнэ гээд оруулаад ирж байна. Усны ашиглалт энэ хэвээрээ явбал Улаанбаатар хот 2030 он гэхэд усны нөөцөө бүрэн шавхана. Тэгэхээр усны нөөц сан бүхий газруудтай болох ёстой. Уул уурхай, арьс ширний үйлдвэрүүдтэй холбоотой хуулийг чангалах шаардлагатай. Харин хөдөө аж ахуйн салбарын усанд болгоомжтой хандах ёстой...” хэмээн анхааруулж байна. Энэ

мэт шалтаг хэлж, хуулийн төслийг орон нутгийн гишүүд хэдэн талаас нь хэмлэсээр унагаж орхисон юм. Гэтэл гишүүдийн эсэргүүцэж буй хуулийг олон малчин дэмждэг. Өнгөрсөн хавар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг орон нутагт ажиллах үеэр Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын уугуул, улсын аварга малчин Б.Баттогтох “Бэлчээрийг хамгаалах гарц, шийдэл нь татвар, төлбөрийн систем” хэмээж байв. Мөн ахмад малчин Б.Шаравсамбуу ч “Малчдыг татвар, төлбөрийн системээр дамжуулан зах зээлд оруулах ёстой. Ингэж байж малын тоо

толгойг зүй зохистой харьцаанд оруулж, бэлчээрээ хамгаалж үлдэнэ” хэмээн хэлж байсан юм. Толгойг нь илсэн төрийн бодлогын балгаар даацаасаа давсан малын хөлд бэлчээрээ талхлуулж буй малчид өдгөө төлөхөд бэлэн гэдгээ илэрхийлэх болсон юм. Харин тариаланчид эсэргүүцэж байна. Усны төлбөр ашиг орлогод нөлөөлж, илүү үнэтэй гурил иднэ хэмээн хэлэх тариаланч байна.


- Мал маллаж, тариалан эрхэлдэг 190 мянга орчим өрх, ААН 60 сая давсан мал, олон мянган га талбайгаа 550 сая шоо метр усаар усалдаг гэж Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас мэдээлж байна.
- Үнэ төлбөргүй тул хайрлах гамнах нь бүү хэл үнэгүй усаар тоглох нь холгүй ашиглах нь энүүхэнд.
- УИХ ус хамгаалах ээлжит хуулийн төслийг “чимээгүй” хойшлуулчихав.

Уг нь энэ нь малчид тариаланчдыг элдэв төлбөр, татвараар дарамтлах зорилго агуулаагүй болохыг албаныхан хэлж байгаа. Харин эдийн засгийн хөшүүргээр дамжуулан усны зохистой хэрэглээнд чиглүүлэх үндсэн зорилготой. Үнэнийг хэлэхэд, Монгол Улсын 169 мянган малчин өрх, 17 мянган тариаланч, аж ахуйн нэгжээс авах энэ төлбөр уул уурхайн ганцхан компанийн усанд төлдөг мөнгөнд хүрэхгүй. Энгийн иргэд, бизнес эрхлэгчдэд төр төмөр нүүр харуулах атлаа малчид, тариаланчдыг яаж ч чадалгүй, эвий минь, хөөрхий минь, усаа үнэгүй ашигла хэмээн хошуу дэвссээр өнөөдрийг хүрлээ. Бидний “ус самрагчид” хэмээн чичилдэг уул уурхайн салбарын ашиглалт усны 10 гаруй хувийг эзэлдэг атлаа 30 гаруй тэрбум төгрөгийн төлбөр төлдөг. Гэтэл бага байна хэмээн байнга чамлана. Цайны сүүгээ арай адан залгадаг хөгшид хүртэл усны мөнгө төлж байхад уулын энгэр дүүрэн мал бэлчээсэн мянгат малчид үнэгүй хэрэглэсээр байна.

Дэлхийн усны 70 хувийг хөдөө аж ахуйн салбарынхан хэрэглэдэг. Тиймээс хөдөө аж ахуйн салбарын усны бодлогод дэлхий дахин анхаарч, усны нөөцийг ариг гамтай ашиглах бодлого хэрэгжүүлж байна. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр дэлхийд дээгүүрт бичигддэг Шинэ Зеландын нэг ферм дунджаар жилд 10-15 мянган ам.долларыг усны төлбөрт төлдөг байна. Энэ хэрээр тус улсын хөдөө аж ахуйн усны хэрэглээ, хамгаалалт хэмнэлттэй агаад уян хатан болж буй.

Гэтэл гадаргынхаа усны 95 хувийг гадагш урсгаад алдчихдаг, жилд 1000 гаруй гол, цөөрөм, булаг шанд ширгэж алга болдог Монгол Улс усанд яагаад ийм хайр гамгүй хандана вэ. Үнэгүй юмыг хүмүүс үрэлгэн л хэрэглэж таарна. Тиймээс эдийн засгийн хөшүүргээр дамжуулан хөдөө аж ахуй, цаашлаад Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах зайлшгүй шаардлага нүүр тулсан. Түүнчлэн мал аж ахуйн салбарын зүй зохистой байдлыг хангаж, мал сүрэг даган доройтож буй экосистемийг авран хамгаалах, усны зохистой хэрэглээг нэвтрүүлэх шаардлага өнөөдөр бидэнд нэн тэргүүнд тулгараад байна. Малчдаасаа татвар авдаг хууль баталчихаад яаж тэднийхээ царайг харах билээ гэсэн хөдөөгөөс сонгогдсон төрийн түшээдийн хий хоосон айдас өнөөдөр усны бодлогыг самрахад хүргээд байна. Хоёр жилийн дараах сонгуулийн ялалтаа хойш тавиад, улс орны үндэсний аюулгүй байдал, орших, эс оршихтой нь холбоотой усыг нэн тэргүүнд үздэг улс төрийн зоригтон өнөөдөр Монголд алга аа. Дэлхий, түүн дээрх хүн, амьтан, ургамал ногоо, бусад амьтай байтугай амьгүй зүйлсийг ч төрүүлсэн “ээж” нь болсон усанд ийм хэнэггүй, хайнга хандсаар байх уу. [ЗГМ]

УХААРАЛ ХАЙРЛАХ УРАН ШОГ



Нийгэм

Шинэ ургац гарч эхэлсэн ч ногооны үнэ өндөр хэвээр байна

Ирэх сард хүнсний ногооны үнэ хямдарна гэсэн хүлээлт үүсчээ

М.Мөнхзул
ЗГМ

Лхагва гарагийн өглөө, 11.00 цаг, Барс зах. Нийслэлийн иргэдийн олноор үйлчлүүлдэг хүнсний бөөний худалдааны төв болох уг захын наймаачид тус тусын контейнераа хэдийнэ нээсэн байлаа. Бидний зорьж очсон төмс, хүнсний ногооны хэсэгт худалдан авагчид харьцангуй цөөн байв. Төмс, лууван тус бүр хоёр килограммыг авахаар жинлүүлж байсан нэгэн эмэгтэй “Шинэ ургац гарчихаад байхад хүнсний ногооны үнэ буухгүй байгааг гайхаж байна” хэмээн хэлэв.

Тэрбээр нэг килограмм төмсийг 2000, лууванг 3000 төгрөгөөр худалдан авсан нь ийн бухимдахад хүргэжээ. Гэлээ гээд хятад ногоо худалдаж авах, эсвэл хүнсэндээ төмс, нарийн ногоо хэрэглэхгүй байх сонголт л түүнд үлдэх тул, үнэтэй ч гэсэн дотоодын ногоог ийн илүүд үзэв.

Тус захын хүнсний ногооны хэсгээр үйлчлүүлж буй бусад иргэн дээрхийн адилаар толгой сэгрэнгээ, тортой ногоогоо барьж одно. Шинэ ургацын хүнсний ногоог өмнөх жилийн өдийнхтэй харьцуулахад 800-



ЗГМ©

1000 төгрөгөөр илүү байв. Гэхдээ өнгөрсөн сард манжин 8000, байцаа 4000 байсныг бодоход шинэ ургацын ногооны үнэ уруудаж л явна. Ирэх сарын эхнээс нийлүүлэлтээ дагаад улам хямдрах биз гэж ногооны худалдаачид хэллээ. Яг ямар шалтгаанаар хүнсний ногооны үнэ өнгөрсөн жилийн өдийнхөөс үнэтэй байгааг тодруулахад “Шинэ ургацын ногоо гарч эхлэхдээ үнэ нь өсдөг. Наймдугаар сар гараад

аяндаа бууна” гэхээс өөр шалтгаан хэлсэнгүй. Барс захын хувьд төмөр замтай ойр, хөдөө орон нутгаас ирж буй хүнсний бүтээгдэхүүнүүдийг бусад захаас харьцангуй хямд худалдаалдаг. Энэ нь ихэвчлэн төмөр замаар авчирсан байдаг тул, тээврийн зардал бага байдагтай холбоотой. Бусад хүнсний захуудын үнэ ч Барсынхаас ялгаагүй байгааг Хүчит шонхор, Таван-Эрдэнэ, Хархорин зэргийн үнэ ханшийн мэдээллээс харлаа.

Сүүлийн жилүүдийн дунджаас харахад манай улс жилд 130 мянга орчим тонн төмс тариалж дотоодын хэрэгцээг бараг 100 хувь хангадаг. Харин бусад хүнсний ногооны 60 гаруй хувийг дотооддоо нийлүүлж байгаа.

Одоо бол олон шат дамжлагаар бус тариаланчдаас хүнсний ногоогоо шууд авдаг болсон. Бид бусад улс, оронтой харьцуулахад хүнсний ногоо бага хэрэглэдэг ард түмэн. Гэхдээ сүүлийн жилүүдэд хүнсний ногоо ихээр

хэрэглэх нь эрүүл мэндэд тустайг ойлгож буй. Хүнсний ногооны үнэ харьцангуй өндөр байгаагай холбогдуулан энэ жилийн ургацын төлөвийг тодруулахад ХХААХҮЯ-нд хандахад “Урьдчилсан мэдээг одоохондоо хэлэхэд эрт” гэсэн тайлбарыг өглөө.

Харин тариалалтын үеийн тайлангаас харахад улсын хэмжээнд төмс 12.7 мянган га-д, хүнсний ногоо 8.1 мянган га-д тариалаад байгаа аж. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ТУСЛАМЖ

Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын буцалтгүй тусламжаар дизель хөдөлгүүрээс ялгарах хөө тортогжилтын ялгарлыг бууруулах зорилготой төслийг үе шаттай хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд нийтийн тээврийн автобусуудад “DPF” шүүлтүүрийг суурилуулах юм.

» НААДАМ

“Даншиг наадам-Хүрээ цам 2018” наадмыг ирэх сарын 4, 5-нд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын Бурхан Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдтэй хамтран “Хүй долоон худаг”-т дөрөв дөх жилдээ зохион байгуулах гэж байна.

» ШАГНАЛ

Ардын хувьсгалын 97 жил, Ардчилсан хувьсгалын 29 жил, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга зарлиг гаргаж нэр бүхий хүмүүст төрийн дээд одон, медаль гардууллаа.

» АВТОЗАМ

Долдугаар сарын 5-ны өдрөөс эхлэн нийт нутгаар хүчтэй аадар бороо орсны улмаас 13 аймгийн нутаг дэвсгэрт хамаарах 29 байрлалд нийт 116 км урт авто зам, замын байгууламжид ноцтой эвдрэл гэмтэл үүссэн байна. Эвдрэлийг сэргээн засварлах ажилд 14 зам хариуцагч байгууллагын 154 хүний бүрэлдэхүүнтэй, 62 машин, механизм ашиглан засварын ажлыг тухай бүр нь гүйцэтгэж байгаа аж. Урьдчилсан байдлаар 1.3 тэрбум төгрөгийн хохирол учраад байна.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: **Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Сургуулийн барилгын өргөтгөл, (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр сургууль) ажил**

Тендер шалгаруулалтын дугаар: **НХААГ-18/0025**

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос **Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Сургуулийн барилгын өргөтгөл, (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр сургууль) ажил”**-ыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж цахим тендерийн баримт бичиг болон холбогдох материалыг татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө тендерт оролцох хураамж болох 50 000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- **Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцох жилийн тоо:** Сүүлийн 3 жил буюу 2015, 2016, 2017 онуудын аль 1 жилийн борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.
- **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх.
- **Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 3 жил /2015, 2016, 2017 он/-ийн аль нэг жилд төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна.
- **Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 3 жил буюу 2015, 2016, 2017 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг нотаритаар баталгаажуулан ирүүлнэ.
- **Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Тийм

1.Зураг төсөл боловсруулах байгууллага нь: Барилга, хот байгуулалтын яамны:

1.2.1 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зураг төсөл

1.2.4 Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

1.2.5 Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10кВ хүртэл), дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл, орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл

1.2.6 Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв

эсвэл;

ЗТ-3.1 Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл
ЗТ-3.3 Үйлдвэр болон агуулахын барилга байгууламжийн технологийн зураг төсөл
ЗТ-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл
ЗТ-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл
ЗТ-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл
ЗТ-6.4 Барилга байгууламжийн дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл
ЗТ-11.2 Барилга байгууламжийн ажлын төсөв

2. Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь: Барилга, хот байгуулалтын яам
эсвэл;

2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт
2.1.2. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил /1-5 давхар хүртэл/ болон түүнээс дээш
2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног

Огноо: 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдөр

төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, холбоо дохиолол, интернэт сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-3.1 Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил
БА-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
БА-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт
БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил

Тендерийн баталгааны үнийн дүн: 25,000,000 (хорин таван сая төгрөг)

Баталгааны хүчинтэй байх хугацаа **2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг** дуустал хүчинтэй байна.

Тендерийг 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 09 цаг 30 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын тендерийн нээлтийн 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 дугаар давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810

Эдийн засаг

Орлого нэмэгдэхээр зарлагаа дагаж өсгөдгөө хэзээ болих вэ

Татварын

орлогоос төлж

буй өрийн хэмжээ

нэмэгдэж байна

◄1Мөн цалингаас бусад бараа, ажил үйлчилгээний төлбөр 4.3 хувиар нэмэгджээ. Улсын нэгдсэн төсвийн “эрүүл мэнд” сайжрах хэрээр Засгийн газрын зардал тэлж, төрийн алба данхайдаг зуршил манай улсад тогтсон. Ялангуяа, орлого давж, эдийн засаг сэргэх тусам энэ үзэгдэл улам хавтгайрч, төр үрэлгэн зантай болчихдог. Харин орлогын төлөвлөгөө тасарч, төсөв сульдах үед төр өр тавьж данхар зардлаа санхүүжүүлэх гэж хамаг л нөөц, бололцоогоо бардаг. Ийм хүнд байдалд улсаараа орж байсан үе саяхан. Харамсалтай нь энэхүү гашуун туршлагаа уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр байгаа тул мартаж, төр зардлаа хумих бус тэлсээр байна.

Төсвийн нөхцөл байдлаа эргэн харцгаая. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2017 оны эхний хагас жилд 676.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч байсан. Тэгвэл энэ оны эхний хагаст 12.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан билээ. Уг үзүүлэлт төсвийн тамир тэнхээг илтгэнэ. Гэвч орлого сайтай жилээ хуримтгал үүсгэж, гал алдах цагт хэрэглэх бус зардал болгон урсгах боллоо. Үүнийг төсөв доторх том тоонуудын хөдөлгөөн харуулж байна.

Тухайлбал, цалингийн хөлс, нэмэлт урамшуулал 942.2 тэрбумд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2.4 хувиар өсөөд байна. Цалин-гийн зардал нэмэгдэж, яамдын бүтэц данхайж буй шалтгааныг Дэлхийн банкны мэргэжилтнүүд сонгуулийн мөчлөгтэй уялдуулсан судалгаа бий. 2000 онд яамдын халаа сэлгээний эргэлт таван хувиас даваагүй байсан бол 2016 оны сонгуулийн дараа 14 хувь болж огцом нэмэгдсэн байна. Энэ тоо албан тушаалтнуудын халаа сэлгээний эргэлт жилд нэг хувийн өсөлттэй байдгийг харуулж байна. Тиймээс ч цалин хөлсний зардал

нь хамгийн том, хурдтай өсөж буй зардлын нэг болж байгаа аж. 2015 онд нийт хөдөлмөр эрхлэлтийн 16.1 хувийг эзэлж байсан төрийн 186.4 мянган албан хаагч 2017 оны эцэст 192.4 мянга болж өсчээ. Харин нэгдсэн төсвийн хуваариар оны эхний хагас жилд 198.1 мянган төрийн албан хаагч ажиллаж байна. Хэдийгээр төрийн албан хаагчдын тоо ийн данхайж буй ч боловсрол, эрүүл мэнд зэрэг төсвөөс цалинждаг

салбарын ажилтнуудын цалин улсын дундажтай харьцуулахад бага өсөлттэй байгаа юм.

Зардал тэлж байгааг илтгэх өөр нэгэн баримт байна. Энэ нь төрийн өмчит компаниудад 30 гаруй тэрбум төгрөгийн татаас олгохоор болсон явдал. Үүнээс 13.9 тэрбумыг нь олгоод байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5.2 тэрбум төгрөгөөр өндөр дүн болж байгаа юм. Гэхдээ энэ оны төсвийг хий ихтэй, хам хум баталсныг



хөрөнгийн зардлын задаргаа харуулна. Энэ онд баталсан хөрөнгийн 1.98 их наяд төгрөгийн зардлын дийлэнхийг буюу 1.2 тэрбумыг барилга байгууламж эзэлж байгаагийн нэлээдгүй хэсгийг цэцэрлэг, сургууль, эмнэлгийн барилга эзэлж буй. Харамсалтай нь, эдгээр барилга байгууламж зураг төслөөсөө эхлээд нэгдсэн норм нормативгүй учир зардал нь тэнгэр газар шиг ялгаатай. Сонгинохайрхан дүүрэгт

байгаа юм. Үүний шалтгааныг оновчгүй төлөвлөлт, популист бодлоготой холбон тайлбарлах нь бий. Эдгээр хүчин зүйл нь төсвийн зардлыг тэлж, улмаар Засгийн газрын өр нэмэгдэхэд хүргэж байна. Төсвийн орлогыг бүрдүүлэх эрдсийн бүтээгдэхүүний үнэ харьцангуй тогтвортой байгаа боловч орлого шинэ хөрөнгө оруулалтад бус төрийн данхар бүтцийн өдөр тутмын урсгал зардал болон үрэгдэж байна. **[ЗГМ]**

хөдөө аж ахуй

Нэг кг ноосны шимтгэлийг 9.3 төгрөг болгож нэмлээ

Зах зээл дээр нэг кг нь 3200-4000 төгрөгийн үнэтэй байгаа ноосны шимтгэлийг кг тутамд нь 9.3 төгрөг болгож нэмсэнээр ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжсэн шийдвэр боллоо. Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, Хөдөө аж ахуйн

бирж хамтран хүсэлт тавьсны дагуу ХХААХҮЯ нэг кг угаасан ноосны 0.32 хувийг шимтгэлийг 15 хувиар нэмэгдүүлж, харин самнасан ноосны шимтгэлийг 0.2 хувь болгож бууруулжээ. Үйлдвэрлэгчдэд ноос 3000 хүртэл төгрөгийн үнэтэй байвал

боломжийн бөгөөд угааж, самнаж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх өртөг одоогийнхоос бага тусна гэдгийг төлөөллүүд онцоллоо. Манай улс дэлхийн ноолуурын хэрэгцээний 40 хувь, тэмээний ноосны 70 хувийг дангаараа хангадаг гэсэн тоон

худалдаа

Lotte Mart ирэх жил Монголд салбараа нээнэ

3.Цэлмэг
ЗГМ

Өмнөд Солонгосын жи-жиглэн худалдааны аварга сүлжээ болох Lotte Mart Улаанбаатарт ирэх оны эхний хагаст салбараа нээхээр төлөвлөж буйг тус улсын Yonhap агентлаг мэдээллээ. Энэ сарын эхээр Lotte групп “Номин Холдинг”-той Монголд жилд гэр ахуйн гурван сая ам.долларын бүтээгдэхүүн экспортлох гэрээ байгуулсан гэдгийг компанийн төлөөлөгч мэдэгджээ.

Lotte групп өнгөрсөн оноос Only Price, Yorihada, Choice L зэрэг хүнсний бүтээгдэхүүнээ “Номин” их дэлгүүрийн сүлжээгээр борлуулж эхэлсэн байна. Хоёр компани ойрын хугацаанд худалдааны жилийн эргэлтээ гурван сая ам.доллар болгохоор зорьж

ЗГМ ТОВЧХОН

» **ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**
Монголын хөрөнгийн биржийн гишүүнчлэлийн журам шинэчлэгдэн батлагдлаа.

» **УУЛ УУРХАЙ**

2.6
Мянга. Монгол Улсад энэ оны эхний хагас жилд хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийн 2.6 мянга буюу 27 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт ажиллаж байна.

» **ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ**

47.6
Хувь. Шинээр хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн ажилгүй иргэдийн хамгийн их буюу 47.6 хувийг ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд эзэлж байна.

» **ТЭЭВЭР**

298.3
Тэрбум төгрөг. Авто тээврийн салбарын орлого энэ оны эхний хагас жилд 298.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 25.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

» **АЖ ҮЙЛДВЭР**

71.8
Хувь. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2018 оны эхний хагас жилд 8.6 их наяд төгрөгт хүрч, 6.2 их наяд төгрөг буюу 71.8 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.

» **БИЗНЕС**

83.1
Мянга. Улсын хэмжээнд статистикийн бизнес регистрийн санд 163.1 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 83.1 мянга нь үйл ажиллагаа явуулж байна.

» **БАНК, САНХҮҮ**

1.3
Их наяд төгрөг. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 1.3 их наяд төгрөгтэй тэнцлээ. Энэ нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.5 хувийг эзэлж байна.

» **төсөв**

80.4
Хувь. Улсын нэгдсэн төсвийн орлогын 80.4 хувийг татварын орлого, 10.5 хувийг татварын бус орлого, 6.8 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 2.3 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,461.28
Евро	2,858.78
Японы иен	21.79
ОХУ-ын рубль	38.91
БНХАУ-ын юань	364.21
БНСУ-ын вон	2.17

ZGM DAILY

Commission on washed wool raised to 15 percent from 0.32 percent

Sheared wool commission lowered to 0.2 percent.

Government to purchase publicly owned shares of Telecom Mongolia

Government offers a price higher than market value to minority stakeholders.

Experts suggest MSE to unlist non-operating firms

Less than 20 companies accounted for 94 percent of stock trades in the first quarter.

Top 20 Index grows 0.32 percent, to 19,701.25 points

Market cap stands at MNT 2.43 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

Prime Minister Khurelsukh Ukhnaa holds a meeting with State Emergency Commission to mitigate flood loss. Related agencies were ordered to take immediate actions to minimize damage and assist households hit by flood.

Mongolian delegation led by Chairperson of the National Statistics Office of Mongolia Ariunzaya Ayush participates in the 29th Population Census Conference, which was held in Da Nang city of the Socialist Republic of Vietnam. At the conference, Ms. Ariunzaya was elected to serve as the President of the Association of National Census and Statistics Directors of America, Asia and the Pacific between 2018 and 2020.

ECONOMY

Financial Regulatory Commission approves revision to the Regulation on Membership.

As of June, 9.6 thousand foreign workers from 92 countries are employing in Mongolia under Labor contracts.

Market capitalization of the Mongolian Stock Exchange grew five times in the last five years. In the same period, the highest growing stock was Suu JSC, jumping 215 times.

Non-performing loans stands at 8.5 percent of outstanding loans. This is 0.3 percent lower than last year's mean time and 0.4 percent growth month-over-month.

Top 20 Index grows 0.32 percent, to 19,701.25 points. MSE A Index increases 0.19 percent, to 9,589.33 points. MSE B Index falls 0.15 percent, to 9,573.69 points. Market cap stands at MNT 2.43 trillion.

SOCIETY

Mongolian children win special place in team's division at the Po Leung Kuk Primary Mathematics World Contest held in Hong Kong from July 14 to July 19.

According to the National Emergency Management Agency, around 2500 citizens were evacuated from flood zones.

MCE raises commission on raw wool to enhance quality



Batsaikhan.S / ZGM©

Manufacturers criticize quality does not come at premium price

Tugsbilig.B
@tugsbiligZGM

Mongolian Commodity Exchange (MCE) raises commission on wool in order to support wool processors and

knitters. The decision was announced yesterday during a press conference, in which the MCE said they respect the request submitted by wool processors, such as Erdenet Carpet LLC, Ulaanbaatar Carpet JSC, Mogol Noos LLC and Sor Cashmere LLC. Accordingly, commission on wool is now MNT 9.3 per kg.

The above-mentioned companies reportedly submitted their request for support to the Ministry of Food, Agriculture and Light Industry in June 2018. After reviewing the request, the ministry has decided to

increase commission on washed wool from 0.32 percent to 15 percent and reduce premium on sheared wool to 0.2 percent. National manufacturers highlighted, “The decision is encouraging wool shearing, manufacturing of final products, and thus, helping export production.”

Presently, wool price fluctuates between MNT 3,200 and 4,000 per kg. MCE officials remarked that the increase in premium on wool is not an attempt to interfere with the market price of wool and is aimed at preventing price bubble and main-

taining sustainability. According to the MCE, the ideal price for wool is MNT 3,000 per kg. By all accounts, this will reduce manufacturing cost of final products and ease price pressure for consumers.

Manufacturers criticized that quality does not come at a premium price. Therefore, they highlighted that herders need to encourage national production by improving the quality of raw materials and get awarded MNT 1,000 per kg.


According to statistics, Mongolia domestically supplies 40 percent

of local demand and 70 percent of camel hair fabric. Last year, national producers processed 67 percent of the wool and 90 percent of the camel hair sales for export production. According to the related ministry, Mongolia has a potential to annually processes over 35,000 tons of wool. National companies currently process about 27,000 tons of wool annually.


Additionally, wool processing representatives highlighted that Mongolia is currently processing fine wool, producing cloths and market-ready products with it. [ZGM]

STOCK MARKET


Gobi JSC (by unit)



Suu JSC (by unit)



Tavan Tolgoi JSC (by unit)



Stock experts call for “going-over” inactive firms

Financial Regulatory Commission recently announced the mandates of 55 companies’ boards, which includes several firms that had their mandates revoked in 2016 and 2017. Analysts criticize the fact that some of these companies remained listed and were traded at the Mongolian Stock Exchange (MSE) until now, and addressed the MSE to “clean-up” inactive companies.

As of today, around 220 SOEs (around 20 percent) and JSCs (80 percent) are listed in tiers I, II and III at the MSE. Since the

beginning of this year, shares of only around 58 percent of these companies were traded and the remaining were completely stagnant. Last trades of some of the “idling” companies’ were supposedly conducted in 1999 and 2000, reported a market analysis firm MarketInfo yesterday. The majority (94 percent) of stock trades conducted at the MSE in the first quarter of this year was generated by less than 20 companies.

Experts also criticized that nearly 40 percent of MSE-listed companies did not hold board

meetings, which is becoming more common in recent years. “These non-operating companies are the results of bad policies with management errors and economic difficulties of transition period and now just titular companies,” said MarketInfo.

As such, reconsideration of some of these companies may be crucial as the lack of information about these “inactive” businesses could impose risks to investors and degrade Mongolia’s stock market now that the public is more actively engaging in stock trades. [ZGM]

Government plans to collect remaining shares of Telecom Mongolia

Telecom Mongolia JSC has announced to purchase 5.33 percent of its publicly owned stakes, allowing complete nationalization of the company. The public shares total 1.38 million units and the company is offering MNT 542 per share until September 19. Telecom Mongolia’s

stock price currently stands at MNT 520 per share.

Earlier this year, the CEO of Telecom Mongolia, told the media that the company will be fully nationalized within 2018. Accordingly, Government bought 40 percent stake of Telecom Mongolia from

KT Corporation, formerly known as Korea Telecom, of South Korea in a USD 2.55 million package deal.

As of today, the Government owns 94.67 percent of Telecom Mongolia and the remaining 5.33 percent are owned by over 3,900 minority shareholders. [ZGM]



МЭДЭГДЭЛ

Юнивишнийн IPTV-ээ бусад өрөөнүүддээ үзэх боломжтой “IPTV салаа” үйлчилгээг урамшуулалтай, хөнгөлөлттэй нөхцөлөөр хэрэглэж байсан хэрэглэгчдийн үйлчилгээний төлбөрийг 2018 оны 08-р сарын 02-ны өдрөөс эхлэн үндсэн үнэ болох 9900 төгрөг болгож байгааг мэдэгдэж байна.

Та бүхэн дэлгэрэнгүй мэдээллийг Юнивишн компанийн лавлах төвийн 1424, 77118811 утсаар лавлах боломжтой.

ЮНИВИШН ХХК



Баримтаас үзэхэд олонх хэрэглэгч утастай хамт ирсэн системийг ашигладаг. Харин бусад өрсөлдөгч апп-уудаас шинээр татаж авдаггүй байна.

Оросууд АНУ-ын бондыг эзэмшихээ эрс багасгав

Макс Седдон

ОХУ АНУ-ын Сангийн яамны үнэт цаасны тэргүүлэгч эзэмшигчдийн нэг байхаа больж байна. Тэгэхдээ тус улсыг олон улсын зүгээс шүүмжлэх явцад Америк дахь эзэмшлээ идэвхтэй зарж байна. Тавдугаар сард 14 тэрбумын урт хугацааны бонд зарсан нь гуравдугаар сард бараг 100 тэрбум байсан эзэмшлийг эрс доошлууллаа гэж АНУ-ын тайланд дурджээ. Вашингтонтой харилцаа нэлээд хүйтэрч, АНУ дөрөвдүгээр сард Оросын эсрэг хориг арга хэмжээ авсан учир ийм алхам хийсэн байж магадгүй. Америкийн хоригт Оросын долоон том бизнесмен, 17 өндөр албан тушаалтан, арав орчим компани багтсан. Мөн хориг анх удаа дэлхийд нөлөөтэй хэлтсийн дарга Эндрю Бреннер “Русал” зэрэг хөнгөн цагаан үйлдвэрлэгчдэд цохилт өгчээ. Үндэсний үнэт цаасны холбооны олон улсын тогтмол орлогын хэлтсийн дарга Эндрю Бреннер “Оросууд хориг болон үнэт цаас зарах эрхэд санаа зовсон учраас борлуулсан байх” хэмээн тайлбарлав. Хоригийг дагаад Оросын үнэт цаасыг зарах үйл явц нэмэгдсэн бөгөөд рублийн ам.долларт харьцуулсан ханш 10 хувь унажээ. Оросын төв банк бондыг худалдсанаа нэг төрлийн санхүүгийн хэрэгслээс хэт хамаарахаас сэргийлсэн арга хэмжээ гэв. Гэвч эдийн засагчдын ярьснаар АНУ-ын конгресс илүү хатуу арга хэмжээ тухайлбал Оросын өрийн бичгийг худалдан авахыг хориглох тухай хууль боловсруулж буйгаас шалтгаалсан байж болзошгүй.

Төлөөлөгчдийн танхимын спикер Пол Райн мягмар гарагт хэлэхдээ Ерөнхийлөгч Трампын

ноён Путинтэй хийсэн зөрчилтэй уулзалтын дараа нэмж хориг тавихдаа “сэтгэл хангалуун” байх болно гэж мэдэгдсэн. Renaissance Capital банкны ерөнхий эдийн засагч Олег Кузьмин эзэмшлээ асар ихээр бууруулснаас үзэхэд зарим талаар геополитикийн асуудалтай холбоотой байх гэв. Гадаад орнууд АНУ-тай худалдааны алдагдлаа зохицуулахын тулд бонд худалдан авдаг. Өөрөөр хэлбэл, тэдний барааг худалдан авсан ам.долларыг буцаагаад АНУ-ын эдийн засагт оруулна. Харин бондыг худалдаж байгаа бол дотоодын валютын ам.доллартай харьцах ханшийг тогтворжуулах зорилготой. Macro Advisory фирмийн шинжээч Крис Вифер “Эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ нь хөрөнгийг хохирлоос зайлуулах эрсдэлийн менежмент юм” гэв.

Орос улс АНУ дахь эзэмшлээ ийн багасгаж байгаа бол бусад орнууд худалдан авахыг эрмэлзэж, тавдугаар сард 27 тэрбум ам.доллараар нэмэгдсэн. Гол эзэмшигчдийн нэг болох Хятад урт хугацааны долоон тэрбумын өртөгтэй бонд худалдан авч, эзэмшлээ 1.18 их наяд ам.долларт хүргэв. Хятад, Америкийн худалдааны зөрчил хурцдаж буй үед ийнхүү худалдан авсан явдал гадаадын хөрөнгө оруулагчид эзэмшлээ буцаан худалдаж, хариу арга хэмжээ авч болзошгүй гэсэн түгшүүр үүсгэсэн. Societe Generale банкны стратегич Субадра Ражалпа “Хятад, Японы зүгээс худалдан авалт багасаж байгаад түгшиж байна. Гэхдээ худалдааны дайн Америкийн бондын худалдан авалтад хэрхэн нөлөөлөхийг хэлэхэд эрт байна” хэмээв.

Google Европын холбоог шүүхэд өгнө гэв

◀1

Google уг шийдвэрт бизнесээ хэрхэн зохицуулах талаар бодож байгаа боловч нөхөшгүй хохирол учрахаас сэрэмжлэн заверын арга хэмжээ авахын тулд Европын шүүхэд хандах аж.

Шүүхээс яаралтай шийдвэр гарах нь нэн ховор. Гэвч бүтвэл Google-ийн саналыг сонсох хүртэл хатагтай Вестагерийн шаардлагад нийцүүлэн бизнесээ өөрчлөн байгуулахыг

хойшлуулах боломжтой. Ноён Пичай “Андройд ашигладаг үйлдвэрлэгчдээс төлбөр авах боломж байсан” гэсэн юм. Баримтаас үзэхэд олонх хэрэглэгч утастай хамт ирсэн системийг ашигладаг. Харин бусад өрсөлдөгч апп-уудаас шинээр татаж авдаггүй байна. ЕХ-ны өрсөлдөөний асуудал эрхэлсэн тэргүүн хэлэхдээ “Google өөрийн хайлтын системийн ноёрхлыг бэхжүүлэхийн тул найман жилийн

турш Андройдыг ашигласан” гэж буруутгасан. Тэрбээр тус компани өрсөлдөгч ба хэрэглэгчдийг хохироосон маш ноцтой хууль бус үйлдэл хийсэн гэж дүгнэжээ.

Дээрх шийдвэрийн дагуу Google ухаалаг утас үйлдвэрлэгчдэд Андройдын Google Play-ыг ашиглуулах нөхцөл болгож Chrome гэх мэт өөрийн бүтээгдэхүүнүүдийг заавал суулгахыг тулгадаг практикаа зогсоох ёстой. Ноён Пичай

урьдаас суулгасан апп-ууд Google-ын үйлчилгээний амжилтын үндэс гэх санааг няцаав. Тэрбээр “Тэдгээрт хүмүүс дуртай учраас л хэрэглэж байгаа. Хүмүүс эрж хайдаг, маш өргөн ашигладаг үндсэн үйлчилгээнүүд манайх” гэсэн байна. Түүнчлэн бүх утсандаа тэдний хайлтын апп-ыг урьдчилан суулгадаг үйлд-вэрлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээ зогсоохыг Google-ээс шаарджээ.

FT

Хятадын сангууд Цахиурын хөндийд \$2.4 тэрбумыг оруулжээ

Дон Вейланд

Сүүлийн хоёр жилд Хятадаас АНУ-д хийх хөрөнгө оруулалт эрс багассан. Гэвч мөн хугацаанд Хятадын гарааны капиталын сангууд Цахиурын хөндийд урьд үзэгдээгүй мөнгө цутгасан байна. Тэд энэ оны эхний таван сард 2.4 тэрбум ам.доллар оруулсан ба цаашдаа өмнөх оны дээд амжилтыг хоёр дахин нэмэх байх гэж Rhodium судалгааны групп мэдээлэв. Холбооны ба био технологид төвлөрдөг гарааны капиталын сангуудын амжилт Трампын захиргаа Хятадад АНУ-ын эмзэг технологи алдагдах боломжийг хаах бодлогын эсрэг хандлага юм.

АНУ-ын эрх баригчид Хятадын хөрөнгө оруулалтыг нарийн хянах үйл явцад хэд хэдэн хэлцэл зогссон билээ. Үүний дотор Canyon Bridge компани Lattice Semiconductor-ыг 1.3 тэрбум ам.доллараар худалдан авах оролдлого нурсан юм. Ийм хүчин чармайлтын үр дүнд 2017 онд АНУ руу хийх Хятадын

шууд хөрөнгө оруулалт 97 хувь унасан. Rhodium-ын мэдээллээс үзэхэд Хятадын гадагш чиглэсэн хөрөнгө оруулалт 2018 оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс 38 хувиар буурчээ. Гэвч жижиг хөрөнгө оруулалт хяналтад өртөлгүй бага эсэргүүцэлтэй тулгарсан аж.

Rhodium группийн захирал Тайло Ханеманн “Хөрөнгө оруулалтын үлэмж хэсэг нь уламжлалт, идэвхгүй аз сорьсон бизнес байсан тул АНУ-ын засаг захиргааны анхаарлыг онц татаагүй” гэжээ. SpaceVR зэрэг технологийн компанид эзэмшилтэй Shanda компанийн захирал Чен Тианкиао “Цэвэр санхүүгийн хөрөнгө оруулалтын хэлбэрийн хувьд өсөлт нь аажим байх болно. Учир нь тийм ч эмзэг салбар биш тул хэлцлийг эхэлж дуусгахад хялбар” хэмээн тайлбарлав. Хятадын гарааны капиталын сангууд гол төлөв хувийнх боловч сүүлийн үед улсын оролцоо нэмэгджээ. Олонх нь цөөн тооны компанийг хамардаг. Гэхдээ технологид нь



оролцдоггүй.

Гэвч ноён Ханеманн “Ийм хөрөнгө оруулалтыг бүрдүүлэх арга нь янз бүр агаад улсын дэмжлэгтэй зарим гарааны капитал хачирхалтай байдаг”-

ийг тэмдэглэв. Томчуудыг нь авч үзвэл Tencent мэтийн интернет ба технологийн группүүд АНУ-ын старт-апад зориулсан мөнгө босгох ажилд оролцсон байна. Бээжинд төвтэй

Tsing Capital сан Америк дахь хөрөнгө оруулалтаа баттерейн технологид төвлөрүүлж, Сиэттийн Wibotic старт-апыг дэмждэг аж. Машин үйлдвэрлэгч SAIC улсын компани Цахиурын

хөндийд гарааны капиталын нэгж байгуулсан ба АНУ-ын тээвэр, зураглал, эрчим хүчний хэд хэдэн компанийг худалдан авчээ.

Хятадын зарим корпораци дэргэдээ гарааны капиталын сан байгуулж, бэлэн мөнгөөрөө хөрөнгө оруулалт хийдэг. Жишээ нь, Шанхайд төвтэй эрүүл мэндийн Wuxi компани Калифорнийн Biosciences-ын багцыг эзэмшдэг аж. Хятадын био технологийн группүүдэд зөвлөгөө өгдөг Hollyhigh фирмийн түнш Чен Бингиу “Биотехкийн хөрөнгө оруулалт хийх эрэлт маш их. Хятадын компаниуд АНУ-ын биотехкийн лиценд олж авахаар нэлээд өрсөлддөг” хэмээв. Rhodium-ын тооцоогоор оны эхний таван сарын гарааны капиталын хөрөнгө оруулалт улсын эзлэх хувь дөрөвний нэг орчим байгаа. Гэвч 2017 оны хоёрдугаар хагастай харьцуулахад энэ чиглэлд улсын үйл ажиллагаа хоёр дахин идэвхэжсэн байна.

FT

Anglo American-ы цагаан алтны ирээдүй өнгөлөг байна

Нил Хьюм

Anglo American-ы Өмнөд Африк дахь уурхай оны эхний хоёр улиралд амжилттай ажилласны дараа цагаан алт үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөө өсгөв. Лондонд бүртгэлтэй уул уурхайн компани энэ онд 2.4-2.45 сая унци цагаан алт үйлдвэрлэнэ хэмээн мэдэгдсэн. Энэ нь өмнөх таамгаас 0.1 саяар илүү байна. Олборлолт ба баяжуулалт сайжирсан тул Mogalakwena уурхайн цагаан алтны үйлдвэрлэл 17



хувиар нэмэгджээ. Түүнчлэн Anglo-гийн зэс ба нүүрсний бизнес сайн гүйцэтгэлтэй

гарсан тул нийт үйлд-вэрлэл зургаан хувь өссөн талаар мэдээлэв.

FT

Alcoa тарифын хайчинд өртжээ

Питер Уэлс

Тус компанийн хөнгөн цагаанд тавьсан Трампын тариф, эрчим хүчний өндөр зардал болон үйл ажиллагааны зарим хүчин зүйлийн улмаас жилийн орлогын төлөвөө буурууллаа. АНУ-ын Питсбург хотын хөнгөн цагаан үйлдвэрлэгчийн хувьд тариф хоёр иртэй мэс мэтээр үйлчилж байна. Гаалийн татварын тодорхойгүй байдал АНУ-д хөнгөн цагааны үнийг өсгөж, оны хоёрдугаар хагаст Alcoa-д ашгийн төлөвөө дээшлүүлэх боломж олгосон. Гэвч тус компани гадаадын салбаруудаасаа АНУ-д



импортлох үйл ажиллагаанаас 15 тэрбум ам.долларын алдагдал хүлээх болж байна. Alcoa-гийн мэдээлснээр тэдний Канад дахь салбараас орж ирэх бүтээгдэхүүнд гаалийн татвар ногдуулсан тул орлого буурах

шалтгаан болсон байна. Тус компани шинэчилсэн таамагтаа 2018 оны орлогын төлөвөө 3-3.2 тэрбум ам.доллараар тооцжээ. Гурван сарын өмнө уг төлөв 3.5-3.7 тэрбум байсан юм.

FT

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР

МНВ	
07.00	“Өглөө” хөтөлбөр
09.00	“Дөлгөөн дон” Оросын ОАК 4-р анги
11.30	“Нандин” ток шоу
13.20	“Хүний мөс” Хятадын ОАК 5-р анги
14.10	“Дөрвөн бэрх”
17.30	Явлаа, ирлээ
18.30	“Олон нийтийн цаг” шууд
19.50	MNB энэ 7 хоногт
21.10	Төрийн шагналт, УГЗ Б.Шаравын II симфонид зориулсан хүндэтгэлийн концерт


БОЛОВСРОЛ

07.05	“Хөгжилтэй математикууп” хүүхэлдэйн кино
09.00	“Монголчууд ХХ зууны эхэнд” нэвтрүүлэг
10.05	“Нисдэг зургаан луу” ОАК 2-р анги
11.15	Үүнийг хэрхэн хийдэг вэ?
13.05	Кино миний амьдрал нэвтрүүлэг
15.50	“Аугаа уран зургууд” нэвтрүүлэг
20.30	“Хүрээлэн” амьд ертөнц
23.50	“Көсөм” ОАК 1.12-р анги



07.40	“Моторын дуу” МУСК
10.30	“Миний алтан амьдрал” СОАК 26-р анги
12.00	“Хавай тав-0” ОАК 9, 10-р анги
13.30	“Руби Спаркс” УСК
15.30	“Чамайг унтаж байхад” СОАК 5,6-р анги
17.30	“Чассс...COOK SHOW” 5-р хэсэг
19.00	“Бээжин хотын залуус” ХОАК 5-р анги
23.30	“Волерин” УСК
01.50	Миний Монголын соёл

ЗУРХАЙ



Билгийн тооллын 8
Зуны адаг шарагчин хонь сарын гурван хөх мэнгэтэй харагчин үхэр өдөр.
Үс засуулбал: Нас уртасна.
Наран ургах, шингэх: 05.15-20.43
Барилдлага: Үл тохирох
Шүтэн барилдлага: Мунхрахуй
Суудал: Шороо
03:53 цагт сар тал болно.

Аргын тооллын долдугаар сарын 20, Сугар гараг. Билгийн тооллын 8, Салхины эх одтой, харагчин үхэр өдөр.
Өдрийн наран 05.15 цагт мандан, 20.43 цагт жаргана. Тухайн өдөр тахиа, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, лус тахих, мал арилжих, буг дарах, газрын ам бооход сайн. Цөөрөм байгуулах, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал нас уртасна.

ОНЦЛОХ ҮЗВЭР

Электро хөгжмийн орон зайг “Интро Улаанбаатар”-аас



“Чехийн хөгжмийн үдэш” тоглолт
Хаана: Улсын филармони
Хэзээ: 2018.10.26
Тасалбарын үнэ: ₮ 25 мянга



Хүн шоргоолж 2 кино
Хаана: “Өргөө” IMAX
Хэзээ: 2018.07.06-наас
Тасалбарын үнэ: ₮ 10-25 мянга



Улсын Филармонийн үзвэрийн 47 дахь жилийн нээлтийн тоглолт
Хаана: Улсын филармони
Хэзээ: 2018.10.12-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 25 мянга


Techno, House хөгжмийн хослол, техникийн хөгжил дэвшилтэй салшгүй холбоотой электроник хөгжмийн орон зайг Улаанбаатарын залууст мэдрүүлэх “Интро Улаанбаатар” анхны олон улсын хэмжээний хөгжмийн фестиваль болох гэж байна. Уг хөгжмийн наадам анх 2009 онд Бээжин хотноо

зохиогдож байсан бөгөөд, Шанхай, Шиедао, Шиамен, Амстердам зэрэг хотуудад жил бүр зохион байгуулж байжээ. Өдгөө “Интро” нь БНХАУ-ын хамгийн том хөгжмийн наадам болсон аж. Харин энэ жилийн “Интро Улаанбаатар” хөгжмийн наадамд Монгол, ХБНГУ,

Франц, Литва, Япон, БНСУ, БНХАУ, Вьетнам зэрэг орноос 20 гаруй DJ ирж оролцох юм. Монгол Улсаас DJ Biliguudei, ТМК нар оролцон, олон улсын уран бүтээлчидтэй хамт фестивалийг “доргиох” юм. Тус хөгжмийн фестиваль ирэх сарын 04-нд Монгол шилтгээнд болно. [ЗГМ]



Hotel Transylvania 3: “Зуны амралт” хүүхэлдэйн кино
Хаана: “Өргөө” IMAX
Хэзээ: 2018.07.11-нээс
Тасалбарын үнэ: ₮ 10-25 мянга




Facebook-ийн сонирхлын бүлгүүдийн уулзалт
Хаана: Үндэсний соёл амралтын хүрээлэн
Хэзээ: 2018.08.01-нээс 05-нд
Тасалбарын үнэ: Үнэ төлбөргүй, урьдчилж бүртгүүлэх шаардлагатай.



“Баянмонгол-50 жил” баярын концерт
Хаана: Соёлын төв өргөө
Хэзээ: 2018.11.23
Тасалбарын үнэ: ₮ 15-30 мянга

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



жил өрсөлдсөн хот, энд зуны олимкийн наадам явагдсан 11. Сэтгэлдээ санасан хорсол, хонзон

ХӨНДЛӨНГӨӨР:
1. Дэлхийн II дайны үеэр Английн нэгэн усан онгоцны багийн гишүүн болж улмаар их гавьяа байгуулж одон медалиар шагнагдсан амьтан
3. Афганистаны хэт даврагч бүлгийн гишүүн
7. Халдваргүйжүүлэх ажил үйлчилгээ
8. Эв, эе, ур
9. 2018 оны VIII сард

Азийн наадмыг анх удаа 2 хотод зохион байгуулах улс
10. Тор тог
12. ОХУ-ын БХЯ-ны сайд, Монгол угсааны гэгдэх эрхэм

(Тува)
13. Дэлхийн улс орнуудын зэвсэгт хүчинд хамгийн түгээмэл хэрэглэдэг зэвсэг (ОХУ-ын автомат буу)

Өмнөх дугаарын хариу / 07.19

С	Ү	Х	Б	А	А	Т	А	Р
А		А	К		А			О
Т	А	Н	К		А	Т	О	М
А		О		Я		А		А
И	Ж	И	Л	М	Ө	Р	Ө	Н
	Э		А		Ш		Р	
	Х	Ө	Г	Ж	Ө	Ө	Н	
	Э		С		Ө		Ө	

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

VII.20 Түр зуурын бороотой 26° 16° 7 м/с 6 м/с	VII.21 Түр зуурын бороотой 24° 18° 6 м/с 4 м/с	VII.22 Түр зуурын бороотой 19° 13° 6 м/с 5 м/с	VII.23 Үүлшинэ 23° 11° 8 м/с 7 м/с	VII.24 Бага зэргийн бороотой 12° 24° 7 м/с 6 м/с
--	--	--	--	--




ФОТО АГШИН



Нүүдлийн соёлтой харшлах энэ үзэгдэл хөдөөд улам олшрох шинжтэй.

ЗГМ: СҮДОКУ

			2	5				7
2						5	4	8
		8					6	
			7	3				4
	2		1		9		7	
6				4	2			
	3					9		
8	7	9						1
4				9	5			

5	9	6	2	4	1	3	7	8
3	2	8	6	5	7	9	1	4
1	7	4	9	3	8	5	2	6
8	3	9	5	6	2	1	4	7
2	4	7	8	1	3	6	5	9
6	1	5	7	9	4	8	3	2
9	6	1	4	7	5	2	8	3
7	8	3	1	2	9	4	6	5
4	5	2	3	8	6	7	9	1

(index нийдэглэл хөнгөд)



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

ЭРЭЭН-УБ	18.00	11.15
УБ-ХӨХ ХОТ	20.00	20.49
ХӨХ ХОТ-УБ	22.50	11.15
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
УБ-ЗАМЫН-ҮҮД	17.20	07.05
ЗАМЫН-ҮҮД-УБ	17.35	08.55



НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	06.10	08.25
БЭЭЖИН-УБ	09.30	12.00
УБ-СӨҮЛ	08.40	12.50
СӨҮЛ-УБ	14.20	17.00
УБ-ТОКИО	07.45	13.40
ТОКИО-УБ	14.40	19.15
УБ-ЭРХҮҮ	07.50	09.15
ЭРХҮҮ-УБ	10.15	11.45
УБ-ХӨХ ХОТ	13.10	15.50
ХӨХ ХОТ-УБ	16.50	19.20
УБ-МӨРӨН	13.30	15.00
МӨРӨН-УБ	15.30	16.50